

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2022/17/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Чойр хот 2022 он</p>	<p>Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543156 Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Г.Наранбаяр Утас: 70543179 Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор Ц.Батсайхан Утас: 70543179 Цахим хаяг: batsaikhants@audit.gov.mn</p> <p>Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс баланс аудит” ХХК Захирал: Ш.Ичинхорлоо Утас: 77270808 Цахим хаяг: nitsbalance@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.6.1 Төсвийн төлөвлөлт.....	14
3.6.2 Төсвийн гүйцэтгэл	14
3.6.3 Нэмэлт төсөв	14
3.7 асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт.....	16
4.1 Залруулсан алдаа.....	16
4.2 Төлбөрийн акт	16
4.3 Албан шаардлага	16
4.4 Зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОУБ	Олон Улсын Байгууллага

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА
А.ЗУРГААНЖИН ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГОВСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.САРАНТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	10,914,248.00	8,315,614.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	582,750.00	1,291,750.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	582,750.00	1,291,750.00
31210	Төгрөг	582,750.00	1,291,750.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	582,750.00	1,291,750.00
33	АВЛАГА	801,500.00	0.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	801,500.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	9,529,998.00	3,901,598.00
35100	Түүхий эд материал	0.00	0.00
35400	Хангамжийн материал	9,529,998.00	3,901,598.00
35410	Бичиг хэргийн материал	1,248,900.00	1,545,600.00
35420	Аж ахуйн материал	3,502,700.00	2,025,500.00
35430	Сэлбэг хэрэгсэл	758,000.00	0.00
35450	Барилгын засварын материал	640,000.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	3,380,398.00	330,498.00
36	НӨӨЦИЙН БАРАА	0.00	3,122,266.00
36600	Бусад нөөц	0.00	3,122,266.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	160,130,710.98	168,746,017.38
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	160,130,710.98	168,746,017.38
39100	Газар	0.00	0.00
39200	Биет хөрөнгө	104,454,910.94	113,395,217.30
39201	Барилга, байгууламж, орон сууц	28,164,100.00	28,164,100.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-938,803.44	-1,408,205.16
39203	Авто-тээврийн хэрэгсэл	69,821,075.00	69,821,075.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-39,487,741.69	-45,087,741.73
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	74,848,216.28	91,611,363.28
39206	Хуримтлагдсан элэгдэл	-38,303,822.66	-45,696,321.54
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	24,282,235.51	18,928,700.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13,930,348.06	-2,937,752.55
39300	Биет бус хөрөнгө	55,675,800.04	55,350,800.08
39301	Програм хангамж	3,040,000.00	3,040,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,064,999.96	-2,389,999.92
39303	Бусад биет бус хөрөнгө	58,608,000.00	58,608,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-3,907,200.00	-3,907,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	171,044,958.98	177,061,631.38
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	171,044,958.98	177,061,631.38
51	Засгийн газрын хувь оролцоо	171,044,958.98	177,061,631.38
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	251,766,128.90	0.00
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	0.00	251,766,128.90
51200	Хуримтлагдсан үр дүн	-103,820,792.01	-97,804,119.61
51210	Өмнөх үеийн үр дүн	-125,180,207.17	-103,820,792.01
51220	Тайлант үеийн үр дүн	21,359,415.16	6,016,672.40
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	23,099,622.09	23,099,622.09
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	171,044,958.98	177,061,631.38

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	639,881,503.66	708,669,877.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	102,642,803.66	20,253,677.10
120	Нийтлэг татварын бус орлого	102,642,803.66	20,253,677.10
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	101,199,603.66	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,350,350.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	97,849,253.66	0.00
120009	Бусад орлого	1,443,200.00	0.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	20,253,677.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	537,238,700.00	688,416,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	526,390,400.00	587,746,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	526,390,400.00	587,746,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,848,300.00	100,669,800.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	12,530,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,848,300.00	86,849,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	1,290,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	594,012,724.82	696,587,653.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	594,012,724.82	696,587,653.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	191,540,583.55	260,357,971.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	112,828,561.00	121,926,046.00
210101	Үндсэн цалин	112,828,561.00	109,799,941.00
210102	Нэмэгдэл	0.00	8,726,105.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	3,400,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,219,472.58	17,062,549.08
210201	Тэтгэврийн даатгал	10,778,250.58	12,334,376.16
210202	Тэтгэмжийн даатгал	907,069.00	1,206,358.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,091,424.00	965,087.99
210204	Ажилгүйдлийн даатгал	222,062.00	223,266.49
210205	Эрүүл мэндийн даатгал	2,220,667.00	2,333,459.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,590,410.00	4,503,121.00
210301	Гэрэл, цахилгаан	326,600.00	337,176.00
210302	Түлш, халаалт	1,915,810.00	1,792,945.00
210303	Цэвэр, бохир ус	269,000.00	105,000.00
210304	Байрны түрээс	2,079,000.00	2,268,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,411,592.66	31,678,121.10
210401	Бичиг хэрэг	1,856,079.00	6,123,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,068,500.00	2,268,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	339,771.00	529,160.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	3,036,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,600.00	4,729,350.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,709,340.00	0.00
210409	Бараа материал шилжүүлсний зардал	18,426,302.66	14,992,011.10

**Говьсүмбэр аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2105	Нормативт зардал	0.00	2,692,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	2,692,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	17,225,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	15,000,000.00
210604	Урсгал засвар	0.00	2,225,900.00
2107	Томилолт, зочны зардал	207,000.00	138,000.00
210702	Дотоод албан томилолт	207,000.00	138,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,962,700.00	45,565,136.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,148,800.00	44,779,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	148,100.00	119,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	143,800.00	135,750.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	0.00	8,736.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,320,847.31	19,566,298.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,554,950.00	599,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,301,100.00	2,161,656.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,464,797.31	16,805,642.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	402,472,141.27	436,229,681.92
2132	Бусад урсгал шилжүүлэг	387,266,193.00	414,866,423.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	220,275,900.00	209,778,423.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	164,822,100.00	204,788,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,168,193.00	300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,205,948.27	21,363,258.92
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,012,498.27	20,182,458.92
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	193,450.00	1,180,800.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	45,868,778.84	12,082,223.64
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	24,509,363.68	6,065,551.24
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал данснас хассаны гарз	24,509,363.68	6,065,551.24
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	21,359,415.16	6,016,672.40

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	251,766,128.90	23,099,622.09	-119,489,784.06	155,375,966.93
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-5,690,423.11	-5,690,423.11
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	251,766,128.90	23,099,622.09	-125,180,207.17	149,685,543.82
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	21,359,415.16	21,359,415.16

Говьсүмбэр аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	251,766,128.90	23,099,622.09	-103,820,792.01	171,044,958.98
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	251,766,128.90	23,099,622.09	-103,820,792.01	171,044,958.98
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	251,766,128.90	23,099,622.09	-103,820,792.01	171,044,958.98
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	6,016,672.40	6,016,672.40
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	251,766,128.90	23,099,622.09	-97,804,119.61	177,061,631.38

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	542,032,250.00	689,217,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,443,200.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,443,200.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,443,200.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,443,200.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	540,589,050.00	689,217,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	526,390,400.00	587,746,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	526,390,400.00	587,746,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,198,650.00	101,471,300.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,620,000.00	12,530,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,509,500.00	87,651,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,069,150.00	1,290,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	540,838,800.00	657,022,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	540,838,800.00	657,022,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	157,920,158.73	220,792,518.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	113,028,987.32	122,456,095.08
210101	Үндсэн цалин	86,980,480.89	91,983,049.08
210102	Нэмэгдэл	17,523,596.43	23,189,982.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,194,710.00	7,283,064.00
210104	Урамшуулал	1,330,200.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,017,721.41	16,532,500.00
210201	Тэтгэврийн даатгал	10,601,352.46	12,434,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,104,127.83	1,024,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	883,322.26	819,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	220,265.57	204,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,208,653.29	2,049,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,590,410.00	4,503,121.00
210301	Гэрэл, цахилгаан	326,600.00	337,176.00
210302	Түлш, халаалт	1,915,810.00	1,792,945.00
210303	Цэвэр, бохир ус	80,000.00	105,000.00
210304	Байрны түрээс	2,268,000.00	2,268,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,298,290.00	11,859,860.00
210401	Бичиг хэрэг	1,056,500.00	5,364,200.00
210402	Тээвэр, шатахуун	3,068,500.00	2,268,200.00

Говьсүмбэр аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	622,600.00	529,160.00
210404	Ном, хэвлэл	211,500.00	183,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	370,700.00	3,130,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	968,490.00	384,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	15,503,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	15,503,500.00
2107	Томилолт, зочны зардал	207,000.00	138,000.00
210702	Дотоод албан томилолт	207,000.00	138,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,280,600.00	46,709,436.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,941,000.00	45,412,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	148,100.00	119,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	143,800.00	135,750.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	124,700.00	148,400.00
210807	Газрын төлбөр	0.00	8,736.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	401,000.00	363,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,497,150.00	3,090,006.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,715,150.00	677,650.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,782,000.00	2,412,356.00
211	ХҮҮ	0.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	382,918,641.27	436,229,681.92
2132	Бусад урсгал шилжүүлэг	366,911,193.00	414,866,423.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	199,920,900.00	209,778,423.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	164,822,100.00	204,788,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,168,193.00	300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,007,448.27	21,363,258.92
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,012,498.27	20,182,458.92
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	994,950.00	1,180,800.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,193,450.00	32,195,500.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,443,200.00	31,486,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,443,200.00	31,486,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,443,200.00	31,486,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,443,200.00	31,486,500.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,443,200.00	-31,486,500.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-249,750.00	709,000.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	832,500.00	582,750.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	582,750.00	1,291,750.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү дүн	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	587,746,400.00	567,563,941.08	20,182,458.92	96.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	587,746,400.00	567,563,941.08	20,182,458.92	96.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	154,361,600.00	152,697,518.08	1,664,081.92	98.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	122,462,900.00	122,456,095.08	6,804.92	100.0
210101	Үндсэн цалин	100,018,800.00	91,983,049.08	8,035,750.92	92.0
210102	Нэмэгдэл	13,894,400.00	23,189,982.00	-9,295,582.00	166.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,776,000.00	7,283,064.00	-507,064.00	107.5
210104	Урамшуулал	1,773,700.00	0.00	1,773,700.00	0.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,532,500.00	16,532,500.00	0.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	12,434,000.00	12,434,000.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,024,600.00	1,024,600.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	819,700.00	819,700.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	204,900.00	204,900.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	2,049,300.00	2,049,300.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,918,100.00	4,503,121.00	1,414,979.00	76.1
210301	Гэрэл, цахилгаан	858,400.00	337,176.00	521,224.00	39.3
210302	Түлш, халаалт	1,677,300.00	1,792,945.00	-115,645.00	106.9
210303	Цэвэр, бохир ус	1,114,400.00	105,000.00	1,009,400.00	9.4
210304	Байрны түрээс	2,268,000.00	2,268,000.00	0.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	4,461,300.00	4,460,860.00	440.00	100.0
210401	Бичиг хэрэг	781,200.00	781,200.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	2,268,200.00	2,268,200.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	529,200.00	529,160.00	40.00	100.0
210404	Ном, хэвлэл	183,300.00	183,300.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	315,200.00	314,800.00	400.00	99.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	384,200.00	384,200.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	179,400.00	138,000.00	41,400.00	76.9
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00	0.00	#DIV/0!
210702	Дотоод албан томилолт	179,400.00	138,000.00	41,400.00	76.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,150,100.00	2,097,936.00	52,164.00	97.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	800,800.00	800,800.00	0.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00	0.00	100.0

**Говьсүмбэр аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210803	Даатгалын үйлчилгээ	148,100.00	119,250.00	28,850.00	80.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	156,800.00	135,750.00	21,050.00	86.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	148,400.00	148,400.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	11,000.00	8,736.00	2,264.00	79.4
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	363,000.00	363,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,657,300.00	2,509,006.00	148,294.00	94.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	241,500.00	96,650.00	144,850.00	40.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,415,800.00	2,412,356.00	3,444.00	99.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	433,384,800.00	414,866,423.00	18,518,377.00	95.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	433,384,800.00	414,866,423.00	18,518,377.00	95.7
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	220,395,300.00	209,778,423.00	10,616,877.00	95.2
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	212,661,500.00	204,788,000.00	7,873,500.00	96.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	328,000.00	300,000.00	28,000.00	91.5
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	587,746,400.00	567,563,941.08	20,182,458.92	96.6
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	587,746,400.00	567,563,941.08	20,182,458.92	96.6
310001	Улсын төсвөөс санхүүжих	587,746,400.00	567,563,941.08	20,182,458.92	96.6
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	8.00	8.00	0.00	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8.00	8.00	0.00	100.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн бүртгэл тайлагнал болон И баримт цахим төлбөрийн баримтын систем, шилэн дансны нэгдсэн цахим хуудасны хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний үндсэн дээр 2022 оны “Эн Ай Ти Эс баланс аудит” ХХК-ийн ахлах аудитор Ц.Энхтуяа, захирал Ш.Ичинхорлоо нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер И.Туяа, дараагийн шатны чанарын хяналтыг төрийн аудитын газрын менежер Г.Наранбаяр, дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар хэрэгжүүлэв.

Говьсүмбэр аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Эн Ай Ти Эс Баланс Аудит ХХК-д хянуулахаар 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 18 тоот албан бичгээр хуульд заасан хугацаанд ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говьсүмбэр аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Боловсролын үйлчилгээнд тэгш хамруулж, чанар хүртээмжийг сайжруулна” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- ЕБС-ийн 1-5 дугаар ангийн сурагчдыг “Үдийн хоол” хөтөлбөрт хамруулж, сургууль бүрийг стандартын шаардлага хангасан хоол үйлдвэрлэлийн байр, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлнэ;
- Сурагчдад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх, тусгай хэрэгцээт хүүдийг сургууль, цэцэрлэгт сурах, хөгжихөд дэмжиж, боловсролын тэгш үйлчилгээнд хамруулна;
- Багш нарын “Мэргэжлийн хөгжлийн бүлэг “ байгуулах;
- Чадварлаг багш хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, багшийн мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэн, хөдөлмөрийн бүтээмжид суурилсан үнэлэмжийг бодитой болгож, нийгмийн баталгааг хангана.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль;
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;

- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” ;
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” ;
- Боловсрол, шинжлэх Ухааны Сайд, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Сайд, Сангийн Сайдын хамтарсан тушаал 2021 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн дугаар А/35/А/10/9.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу санхүүгийн тайлан бэлтгэж, тайлагнасан байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны баталсан төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэлийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны төсөвт зардлын хүлээгдэж буй гүйцэтгэл 696,587.7 мянган төгрөгийн 2.0 хувь буюу 13,931.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75.0 хувиар тогтоов.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говьсүмбэр аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,016.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	582.7	1,291.7	709.0
Авлага	801.5	-	-
Бараа материал	9,530.0	3,901.6	-5,628.4
Нөөцийн бараа		3,122.3	3,122.3
Үндсэн хөрөнгө	160,130.7	168,746.0	7,615.3
Нийт хөрөнгө	171,044.9	177,061.6	5,016.7
Богино хугацаат өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	171,044.9	177,061.6	5,016.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	171,044.9	177,061.6	5,016.7

Тайлант онд авлагын эхний үлдэгдлийг барагдуулсан ба шинээр авлага үүсгээгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 5,628.4 мянган төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын материалын дансны эхний үлдэгдлийн бууралтаас шалтгаалсан байна.

Нөөцийн материалын дансанд 2021 оны сүүлээр БШУЯ-наас ирүүлсэн ерөнхий боловсролын сургуулиудад хуваарилах зориулалттай номыг бүртгэж тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 7,615.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 30,614.9 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, 19,834.0 мянган төгрөгийн хөрөнгийг хандиваар хүлээн авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 177,061.6 мянган төгрөг болж 5,016.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд 5,016.7 мянган төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой байна.

Говьсүмбэр аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого 708,669.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 68,788.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Нийт орлого өмнөх оноос өссөн нь дараах нэр төрлийн орлогуудын материаллаг хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалсан байна. Үүнд:

- Урсгал үйл ажиллагааны санхүүжилт 61,356.0 мянга;
- Нэмэлт санхүүжилтийн орлого 89,821.5 мянган төгрөгөөр тус тус өссөн бол
- Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого 3,350.3 мянга;
- Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 77,595.5 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт зардал 696,587.7 мянган төгрөгт хүрч өмнөх оноос 102,575.0 мянган төгрөг буюу 17.3 хувиар өссөн байна. Нийт зардлын өсөлт нь бараа ажил үйлчилгээний зардал 68,817.4 мянга, урсгал шилжүүлэг 33,757.6 мянган төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 206,079.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв батлахдаа төсвийн төслийг 360,922.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 567,001.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор улсын төсвийн санхүүжилтийг 20,745.4 мянган төгрөг буюу 3.6 хувиар нэмэгдүүлсэн 587,746.4 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 3 зориулалт, арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 587,746.4 мянган төгрөгийг баталснаас 559,534.6 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Тайлант оны улсын төсвийн санхүүжилтийг бүрэн авч зарцуулсан байна.

Баталсан нийт төсөвт зардлын гүйцэтгэл 567,563.9 мянган төгрөг буюу 95.2 хувийн гүйцэтгэлтэй гарч, баталсан төсвийг 20,182.4 мянган төгрөг буюу 4.8 хувиар хэмнэсэн байна.

Баталсан нийт зардлын хэмнэлт нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын 1,415 мянга, урсгал шилжүүлгийн зардлын 18,518.4 мянган төгрөгийн хэмнэлтүүдтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 86,470.5 мянга, орон нутгийн төсвөөс 12,530.0, ахмадын сангийн орлого 1,290.0 мянга, нийт 100,290.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж, бараа материалын зардалд 7,399.0 мянга, техник тоног төхөөрөмж худалдан авах зардалд 44,000.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 47,601.5 мянга, бараа үйлчилгээний бусад 851.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд “Боловсролын үйлчилгээнд тэгш хамруулж, чанар хүртээмжийг сайжруулна” зорилтын хүрээнд дараах хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажил хийсэн байна. Үүнд: ОУБ-ын төслийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн ширээ сандал, гал тогооны төхөөрөмж, угаалгын өрөөний тоног төхөөрөмжийг “Аяганы хонхор цэцэрлэг”-т,

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэгт, Шивээ говь сумын цэцэрлэгт нийт 11,800.0 мянган төгрөгийн ширээ сандал бэлтгэн тус тус хүлээлгэн өгсөн.

Дэлхийн банкны хөрөнгө оруулалтаар баригдаж буй 5 дугаар цэцэрлэгийн 640 хүүхдийн барилгын ажлын 70.0 хувийн гүйцэтгэлд хяналт тавих зэрэг төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажилласан байна.

3.8 Аудитын гол асуудал

Боловсрол, соёл, урлагийн газар 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 31 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, бүрэн хэрэгжүүлэн ажилласан биелэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант онд шилэн дансны нэгдсэн системд байршуулбал зохих 149 мэдээллээс 11 мэдээллийг 1-3 сар хугацаа хоцроож байршуулсан.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Татварын ерөнхий хуулийн хэрэгжилт

Тайлант хугацааны худалдан авалтын төлбөрийн баримтыг И баримт цахим төлбөрийн системд 3,546.0 мянган төгрөгийн төлбөрийн баримтыг шивүүлж, баталгаажуулаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн зарим худалдан авалтын төлбөрийн баримтыг цахим системд дутуу шивүүлсэн, төлбөрийн баримтын баталгаажуулалтад хяналт тавиагүй нь Татварын ерөнхий хуулийн тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 2 төлбөрийн акт, 1 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн, 1 албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байгаагаас тайлант онд зарим зөрчил давтагдсан, өгсөн 9 зөвлөмж хэрэгжсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил

хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, бараа материалын нөөц, үлдэгдлийн шалтгааныг нарийвчлан тогтоох нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 14,836.0 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрсэнд 4 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга хийгдээгүй.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

4.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Нэмэлт санхүүжилтийн дансанд ахмадын сангийн орлого, зарлагын ажил гүйлгээг бүртгэж, тайлагнасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4.1 "төсвийн захирагч нь дараах нэмэлт төсвийг холбогдох арга хэмжээнд зарцуулж болно", 47.1.5 ".....төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого" гэсэн заалтуудыг зөрчсөн.

1.2. Өгсөн зөвлөмж:

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуульд заасан 4 төрлийн орлого, зарлагын ажил гүйлгээнээс орлого, зарлагын гүйлгээг бүртгэж, тайлагнахгүй байх.

2. Хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант онд ЕБС-уудад хуваарилах зориулалтаар бэлтгэсэн хөрөнгийг үндсэн хөрөнгийн тайланд бүртгэж, тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцээгүй, "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Хуваарилах, худалдан борлуулах зориулалттай үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэж, тайлагнаж байх.

3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Тайлант онд шилэн дансны нэгдсэн системд байршуулбал зохих 149 мэдээллээс 11 мэдээллийг 1-3 сар хугацаа хоцроож байршуулсан.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д: "тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх гэсэнтэй нийцээгүй,

3.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийг мөрдөж, Шилэн дансны нэгдсэн цахим системд байршуулбал зохих мэдээллийг үнэн зөв, хугацаанд нь байршуулж байх.

4. **Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал**

4.1. Илрүүлэлт:

Тайлант хугацааны худалдан авалтын төлбөрийн баримтыг И баримт цахим төлбөрийн системд 3,546.0 мянган төгрөгийн төлбөрийн баримтыг шивүүлж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д: "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэсэнтэй нийцэхгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

И баримт цахим төлбөрийн баримтын системд худалдан авсан бараа, ажил үйлчилгээний төлбөрийн баримтыг тухай бүр шивүүлэн баталгаажуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мян төг/

Д/д	Зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс								
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1.1	Тайлант онд ЕБС-уудад хуваарилах зориулалтаар бэлтгэсэн хөрөнгийг үндсэн хөрөнгийн тайланд бүртгэж, тайлагнасан.	1	10,000.0								1	10,000.0
1.2	Нэмэлт санхүүжилтийн дансанд ахмадын сангийн орлого, зарлагын ажил гүйлгээг бүртгэж, тайлагнасан	1	1,290.0								1	1,290.0
2	Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
2.1	Е баримт цахим төлбөрийн системд төлбөрийн баримтыг шивүүлэхдээ 3,546.0 мянган төгрөгийн төлбөрийн баримтыг шивүүлж, баталгаажуулаагүй	1	3,546.0								1	3,546.0
2.2	Тайлант онд шилэн дансны нэгдсэн системд байршуулбал зохих 22 мэдээллээс 11 мэдээллийг 1-3 сар хугацаа хоцроож байршуулсан	1									1	
	Нийт дүн	4	14,836.0								4	14,836.0

